Монголын Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилгыг зохион байгуулах, хянан зохицуулах үүрэг бүхий Үндэсний зөвлөлийн аравдугаар хуралдааны тэмдэглэл /2012-11-28/

Үндэсний зөвлөлийн аравдугаар хуралдаан 2012 оны 11 дүгээр сарын 28-ны өдрийн 17 цаг 00 минутад Төрийн ордны "Нутгийн удирдлагын танхим"-д эхлэв.

Хуралдаанд Үндэсний зөвлөлийн дарга, Монгол Улсын Ерөнхий сайд Н.Алтанхуяг, Байгаль орчин, ногоон хөгжлийн сайд С.Оюун, Монгол Улсын Ерөнхий аудитор А.Зангад, Үндэсний статистикийн хорооны дарга С.Мэндсайхан, Монголын Уул уурхайн үндэсний ассоциацийн ерөнхийлөгч Д.Дамба, Монголын алт МАК ХХК-ийн дэд ерөнхийлөгч Г.Цогт, Монполимет ХХК-ийн гүйцэтгэх захирал С.Энхтуяа, Монголросцветмет ХХК-ийн хангамжийн хэлтсийн дарга М.Болдбаатар, Петрочайна дачин тамсаг ХХК-ийн гүйцэтгэх захирал С.Мэргэнсод, Нээлттэй нийгэм форумын менежер Н.Дорждарь, Хүний эрх, хөгжил төвийн тэргүүн Г.Уранцоож, Хил хязгааргүй алхам ТББ-ын тэргүүн Н.Баярсайхан, Монголын байгаль орчныг хамгаалах холбооны тэргүүн Н.Бадамханд, Миний Монголын газар шороо хөдөлгөөний тэргүүн Б.Болдбаатар, Ил тод сан ТББ-ын гүйцэтгэх захирал Д.Цэрэнжав, Ариун суварга хөдөлгөөний тэргүүн Г.Чагнаадорж, Монголын байгаль орчны иргэний зөвлөлийн удирдах зөвлөлийн гишүүн Б.Батболд, Ерөнхий сайдын ахлах зөвлөх, Үндэсний зөвлөлийн нарийн бичгийн дарга Л.Гансүх нар оролцов. Мөн Сангийн сайд Ч.Улааныг орлож Сангийн дэд сайд С.Пүрэв, Үндэсний зөвлөлийн орлогч дарга, Уул уурхайн сайд Д.Ганхуягийг орлож Уул уурхайн яамны Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын мэргэжилтэн Б.Хулан, Монгол Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооны дарга Ц.Даваасүрэнг орлож Төсвийн байнгын хорооны референт Ц.Батбаатар, Авилгатай тэмцэх газрын дарга Н.Ганболдыг орлож Авилгатай тэмцэх газрын Тамгын хэлтсийн дарга Ж.Наранбаатар, Оюу толгой ХХК-ийн ерөнхийлөгч Камерон Макрейг орлож дэд ерөнхийлөгч С.Отгонбат, Энержи ресурс ХХК-ийн гүйцэтгэх захирал Г.Батцэнгэлийг орлож компанийн нийгмийн хариуцлага, олон нийттэй харилцах газрын дарга З.Сугармаа нар хуралдаанд оролцов. Хуралдаанд Үндэсний зөвлөлийн 30 гишүүдээс 24 гишүүд оролцож ирц 80 хувьтай байв.

Мөн хуралдаанд урилгаар Татварын ерөнхий газрын дарга Б.Баттөмөр, Ашигт малтмалын газрын дарга Г.Алтансүх, БОНХЯ-ны Байгалийн нөөцийн газрын дарга Д.Энхбат, Сангийн яамны Нягтлан бодох бүртгэлийн газрын ахлах мэргэжилтэн Б.Болормаа, АМГ-ын мэргэжилтэн Д.Мөнхсайхан, ТЕГ-ын ахлах байцаагч Д.Энхтуяа, Оюу толгой ХХК-ийн олон талт хамтын ажиллагааны ахлах мэргэжилтэн Х.Лхамаа, мэргэжилтэн О.Адъяа, Петрочайна дачин тамсаг ХХК-ийн гүйцэтгэх захирал Б.Дэлгэрбаяр, Улаанбаатар аудит корпораци ХХК-ийн ерөнхий захирал Б.Осоргарав, ахлах аудитор Н.Эрдэнэцог, ахлах аудитор Б.Мэндбаяр, ОҮИТБС-ын ажлын албаны зохицуулагч Ш.Цолмон, санхүүгийн мэргэжилтэн Б.Дэлгэрмаа нар оролцов.

Хуралдааныг Үндэсний зөвлөлийн нарийн бичгийн дарга, Ерөнхий сайдын ахлах зөвлөх Л.Гансүх нээж мэндчилээд, хуралдаанаар хэлэлцэх 6 асуудлыг танилцуулж, хуралдааны дотоод журмыг гишүүдээс санал авж баталснаар хуралдааныг эхлүүлэв.

I. ХЭЛЭЛЦСЭН нь: Их Британийн Харт Нойрс лдт болон Монголын Улаанбаатар аудит корпораци ХХК-ийн хамтарсан консорциумын хийж гүйцэтгэсэн Монгол Улсын ОҮИТБС-ын зургадугаар буюу 2011 оны нэгтгэлийн тайланг батлах тухай

Б.Осоргарав: Та бүхний энэ өдрийн амар амгаланг айлтгая гэж мэндчилээд Монгол Улсын ОҮИТБС-ын зургадугаар буюу 2011 оны нэгтгэлийн тайланг товч танилцуулав. /Танилцуулгыг хавсаргав/

Л.Гансүх: Бид энэ тайлангийн явц, дүнг ажлын хэсгийн хурлаараа 2 ч удаа хэлэлцсэн. Үндэсний зөвлөлд ажлын хэсгийн нилээн хэдэн гишүүд орж ажиллаж байгаа, тэдгээр гишүүд маань тайлантай холбоотой хангалттай мэдээлэлтэй байгаа байх. Бид хуралдаанаас өмнө энэхүү тайланг цахим болон хэвлэмэл хэлбэрээр урьдчилан тараасан. За тэгээд тайлантай холбоотой асуух асуулттай хүн байна уу?

Б.Осоргарав: Энэ удаагийн тайлан маань нийт 1800 гаруй хуудас бүхий 3 боть тайлан, мөн түүнчлэн CD-нээс бүрдэж байгаа.

Н.Алтанхуяг: Надад хоёр асуулт байна. Энэ асуултаа асуучихаад, дараа нь хуралд үгээ хэлье. Тэгээд та бүхэн хуралдаанаа үргэлжлүүлээд яваарай. Нэгдүгээрт, та сая танилцуулга дээрээ эхлээд 400 гаруй тэрбум төгрөгийн зөрүү үүсээд, үүнийг нягталсаар байгаад 300 гаруй сая төгрөгний зөрүү үлдсэн гэсэн үү? Үүнийг ахиад тайлбарлаад өгөхгүй юу?, Хоёрдугаарт, тэр 58 компани тайлангаа ирүүлээгүй гэж байна. Тайлангаа ирүүлэх ёстой юу?, ирүүлээгүй тохиолдолд ямар арга хэмжээ авдаг юм бэ?

Б.Осоргарав: Анхны нэгтгэлээр буюу Засгийн газрын тайланг, компанийн тайлантай тулгаж үзэхэд анх 477 тэрбум төгрөгний зөрүү үүссэн. Үүнийг бид яагаад зөрүү үүсэв гэж нягтлан шалгаж, тодруулга хийдэг. Ингээд хамгийн сүүлд шийдэгдээгүй үлдсэн зөрүү нь нийт 622 сая төгрөг буюу компанийн талд 278 сая, Засгийн газрын талд 344 сая төгрөгний зөрүү үлдсэн. Энэний цэвэр зөрүү нь 74 сая төгрөг болж байна. Хоёрдугаарт, 58 компани ОҮИТБС-ын тайлангаа гаргаагүй байсан. Бид үүнийг нэгтгэлийн явцад нөхөж гаргуулж, тулгалт хийсэн байгаа.

Н.Алтанхуяг: Бас нэг асуулт байна. Энэ улсын төсвийн орлогын 30-40 хувийг ил тод болгож байна гэсэн байна. Энэ уул уурхайтай холбоотой орлогыг хэлж байна уу?

Б.Осоргарав: Тийм.

Н.Алтанхуяг: За надад хурал нээж хэлэх үг бэлдсэн байсан юм. Гэхдээ энэ бүгдийг уншмааргүй байна. Миний хувьд анхны хурал учраас ерөнхийдөө танин мэдэхүйн чанартай зүйлсээ ойлгоод авлаа. ОҮИТБС-ын Үндэсний зөвлөл нь их чухал зөвлөл юм байна. Яагаад гэвэл ОҮИТБС-ын Үндэсний зөвлөл сайн ажиллавал Шинэчлэлийн Засгийн газрын "Ил тод, хариуцлагатай уул уурхайг хөгжүүлнэ" гэсэн бодлогыг хэрэгжүүлэхэд их чухал хувь нэмэр оруулахаар харагдаж байна. Мөн

түүнчлэн Засгийн газар, компани, иргэний нийгэм гэсэн гурван талын субъект ил тод байдлыг хангах чиглэлээр хамтран ажиллаж байгаа нь их сайшаалтай байна.

За тэгээд өмнө нь Үндэсний зөвлөл жилдээ 1-2 хуралддаг байсан юм байна. Үүнийг болж өгвөл улиралдаа 1 ч юмуу хуралддаг болгоод иргэддээ явцын мэдээллийг сайн өгөх хэрэгтэй гэж бодож байна. Шинэчлэлийн Засгийн газрын хүсээд байгаа зүйл бол ерөөсөө иргэний нийгэм, компани, Засгийн газар бүгд л ажлаа аль болох ил тод л ярьмаар байгаа юм. Тэр хаалттай байдлаа зогсоох хэрэгтэй. Тийм учраас Засгийн газрын тэргүүний хувьд энэ ил тод байдлын санаачилгыг бүх талаар нь дэмжиж ажиллана гэдгээ нотлон хэлье.

Осоргарав гуайн танилцуулгаас сонсож байхад хариуцлага тооцдог механизм нь тодорхойгүй гэж байна. Үүнийг л тодорхой болгох хэрэгтэй. Түүнээс сайн дурын уран сайхан ч шиг байж болохгүй. Бас нэг ноцтой юм нь компани өгсөн гээд байдаг, хүлээж авсан төрийн байгууллага нь аваагүй гэж байна. Ийм байж болохгүй ээ. Үүнийг хууль хяналтын байгууллагад нь өгч шалгуулах ёстой. Шаардлагатай бол Засгийн газар оролцоод энэний учрыг олъё. Та бүхэн энэ дээр анхаарч ажиллаачээ. Зүгээр нэг хуралдаад хэдэн тоо ярьдаг биш эндээс тодорхой санал, дүгнэлт гаргаад хэдүүлээ идэвхтэй ажиллая.

Анх Их Британи энэ санаачилгыг санаачилаад, манай улс нэгдэн орсон нь их сайшаалтай юм. Тэгээд иргэний нийгэм, компани, Засгийн газар хамтраад уул уурхайн салбарт хэдий хэмжээний мөнгө бий болж байна, үүний хэдийг нь татварт өгч байна, хэдийг нь хандивт өгч байна, байгаль хамгаалах ажилд хэдийг төлөвлөөд, хэдийг зарцуулсан гэх зэрэг нарийн олон асуудлууд хөндөгдөж байна. Аудитын дүгнэлт ерөнхийдөө их олон болчихож. Үүнийг их тодорхой болгож энэ хурлаас гаргаачээ гэж зөвлөлийн гишүүддээ хэлэх байна. Эндээс гарсан дүгнэлтийг Засгийн газар анхааралдаа авч, ажил болгоход иргэний нийгэм, компаниудтайгаа хамтран ажиллая.

Хандив гэдэг асуудлыг ер нь хязгаарлах хэрэгтэй. Компани яахав хандив гэж бүртгэж байгаа боловч ер нь тэдэнд тулган шаардаж байгаа дээрэм маягийн л зүйл шүү дээ. Хандив бол сайн дурынх байх ёстой. Бид аймгуудтай цахим хурал хийж байгаа. Тэдэнд сайн анхааруулъя.

Эцэст нь хэлэхэд та бүхэн ийм их ажил, бичиг цаас үйлдвэрлэж байгаа юм чинь юуг хийж болох, юуг хийж болохгүй гэх зэрэг сайн сайн дүгнэлтүүдийг гаргаж өгөөрэй гэж хүсэх байна. Ингээд та бүхний ажилд амжилт хүсье. Засгийн газар илүү нягт хамтран ажиллах болно шүү.

Л.Гансүх: За Ерөнхий сайддаа баярлалаа. Өөр асуулттай хүн байна уу?

Г.Чагнаадорж: Өмнө нь ажлын хэсгийн хурал дээр ч энэ тухай ярьж байсан. Аудитад бид 200 компанийг оруулж байна. Гэтэл АМГ-ын мэдээлснээр 1800 гаруй компани 3000 гаруй лиценз эзэмшиж байна. Бүх компаниуд тайлангаа өгөхгүй байгаа нь учир дутагдалтай байна. Тайлан өгдөггүй компаниудын лицензийг нь хураж авч болдоггүй юмуу? Хоёрдугаарт, газрын тосны компаниудын талаарх мэдээлэл бидэнд их

хомс байдаг. Яагаад газрын тосны компаниудын мэдээлэл олон нийтэд түгээмэл биш, хаалттай байдаг юм бэ? Үүнийг Засгийн газрыг төлөөлж ирсэн хүмүүсээс асуумаар байна.

Л.Гансүх: Нэгтгэлийн тайланг бид 6 дахь жилдээ гаргаж байна. Өмнөх жил 150 компанийг аудитад хамруулсан. Өмнөх жилүүдээ бодоход харьцангуй аудитад орох компанийн тоо нэмэгдэж байгаа. Гэхдээ энэ жил хэдүүлээ бүх компанийг л тайлан гаргуулах тал дээр анхаарч ажиллая. Хоёрдугаарт, урьд оны тайланд гардаг байсан олон дутагдлыг арилгая гэдэг үүднээс тайлангийн маягтыг шинэчлэх, тайлан авдаг журмаа өөрчлөх дээр анхаарч ажиллаж байна. Энэ тухай дараагийн асуудлууд дээр танилцуулна. Тэр үед таны асуусан асуултад хариулаад явъя.

Г.Уранцоож: Тайланд хамрагдах компаниудын тоо нэмэгдэж байна, тайланг орон нутгийн түвшинд гаргаж байна гэх зэрэг дэвшилттэй зүйл бол байна. Гэхдээ жил бүр л хандивын асуудал дээр зөрүү гарч байдаг. Үндэсний зөвлөлд Авилгатай тэмцэх газрын төлөөлөл байдаг шиг санагдаад байна. Авилгатай тэмцэх газар нь хандив, дэмжлэг дээр гарсан зөрүүний мөрөөр ажиллаж байсан уу? Тодорхой арга хэмжээ авч байсан уу? гэж асуумаар байна. Хоёрдугаарт, нэг санал байна. Жил бүр энэ хандив, дэмжлэг дээр гарсан зөрүүг шалгаж, ямар арга хэмжээ авсан талаараа Авилгатай тэмцэх газраас Үндэсний зөвлөлд танилцуулдаг байя. Тэгэхгүй бол энэ нэгтгэлийн ажил ач холбогдолгүй болоод байна.

Ш.Цолмон: АТГ нь Үндэсний зөвлөлд анхнаасаа гишүүнээр ажиллаж ирсэн. Хандивтай холбогдсон зөрүүг шалгах, арга хэмжээ авахад хууль эрх зүйн орчин бүрэлдээгүй гэсэн үндэслэлээр өнөөг болтол тодорхой арга хэмжээ авч ирээгүй. Хоёрдугаарт, Үндэсний аудитын газарт асуудлыг тавихад мөн адил төрийн байгууллагуудыг хянан шалгаж болно, компаниудыг хянаж шалгах эрх байхгүй гэсэн тайлбар хэлдэг байсан. Мэргэжлийн хяналтын ерөнхий газарт асуудлыг тавихад манай хариуцах асуудал биш байна гэх мэтээр байгууллагууд асуудлыг хойш тавьж ирсэн.

Ж.Наранбаатар: Өнөөдрийн байдлаар Үндэсний зөвлөлөөс хандивтай холбоотойгоор ийм ийм төрийн байгууллага, албан тушаалтан, төрийн өмчит компанийг шалгаж өгнө үү гэсэн өргөдөл, гомдол манайд нэг ч ирээгүй байна. Хэрэв тийм өргөдөл, гомдол гаргавал бид Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн дагуу шалгаж болно оо.

Л.Гансүх: Би энэ ажлыг аваад 2 сар болж байна. Энэ хугацаанд Монгол Улсын ОҮИТБС-ын 6 дугаар нэгтгэлийн тайланг батлах асуудлыг хэлэлцэж ирлээ. Өмнө нь тайлантай холбоотой олон асуудлыг сонсоод л өнгөрдөг байсан юм байна лээ. Энэ удаад ажлын хэсэг асуудлыг илүү нухацтай авч хэлэлцээд Үндэсний зөвлөлд илүү тодорхой асуудлуудыг оруулж ирж байна. Тухайлбал, тайлан гаргаагүй компаниудтай ямар хариуцлага тооцох талаар АМГ-ын даргын санал, хандив, тусламжийг бүртгэх тухай Сангийн сайдын 45-р тушаалын хэрэгжилтийн байдлын талаар Сангийн яамнаас мөн адил танилцуулга, санал бэлдэж ирсэн байгаа. Бид 2012 оны тайланг арай өөр түвшинд гаргая гэж зорьж байна. Аливаа нэг юманд эхлэх цэг гэж байдаг. Тэгвэл бид одооноос нэгтгэлийн ажлыг арай өөр түвшинд аваачнаа. Бид урагшаагаа харж ажиллах ёстой. Ажлын хэсэг, Үндэсний зөвлөл нь гурван талын тэгш төлөөллөөс бүрддэг. Тийм

учраас хэн нэгэн хүнд дангаар хариуцлага үүрүүлэх юмуу тийм асуудал байхгүй, протоколоо сайн хөтөл, ажлын хэсэгт сайн шаардлага тавь, Үндэсний зөвлөлд өөрсдийн төлөөллөөрөө дамжуулж бичгээ өг. Түүнээс хэн нэгэн хүн хариуцдаг, нөгөөдүүл нь шахан биелүүлүүлдэг гэсэн ойлголт байхгүй. Бүгд л адилхан шаардлага тавьж, хариуцлага хүлээх ёстой. Тэгээд урьдны тайлантай холбоотой асуудал байвал нээлттэй хүлээж авнаа. За өөр асуулттай хүн байна уу?

Б.Болдбаатар: Яг дан уул уурхайн ашиг орлогын асуудлыг ил тод болгож чадаж байна уу? Тухайлбал, нэгтгэлд М-Си-Эс, Гацуурт гэх мэт уул уурхайгаас гадна давхар өөр төрлийн бизнес эрхэлдэг групп компаниуд орсон байх юм. Эдгээрийн дан уул уурхайгаас орлого олоод төлсөн татварыг нь салгаж гаргаж чадаж байгаа юу? Хоёрдугаарт, ураны 180 лиценз шилжүүлсэн гэж яригдаад байдаг. Энэ асуудал юу болж байна? Энэ талаар ил тод нээлттэй мэдээлэл алга байна. АМГ-ын вэб хуудас руу ороод хардаг, энэ талаарх мэдээлэл байхгүй байна. Газрын тосны 13 компанийн талаар түрүүнд асуусан. Энэ асуултад хариулт өгсөнгүй. Би энэ санаачилгын ажлын хэсгийн гишүүнээр 7 жил ажиллаж байна. 3000 гаруй лиценз, 1800 гаруй компанийн асуудал яригдаж байна. Үүнийг тодорхой болгомоор байна. Тэгэхгүй бол 200 гаруй нь аудитад ороод байдаг, бусад нь тайланд хамрагддаггүй, лицензээ хоорондоо шилжүүлээд л лицензийн наймаачид шиг явж байх юм. Үүнийг тодорхой болгож өгөөчээ.

Л.Гансүх: Өмнөх жилийн хурлаараа энэ жилийн аудитын нэгтгэлийн талаар ярьж байсан байх. Би бол өнөөдрийн хурлаар ирэх жилийн аудитыг яаж хийх юм, хэдэн компанийг аудитад оруулах юм гэх зэрэг асуудлуудаа хэлэлцэнэ. Тэгэхээр одоо ингэж асууж байхыг бодоход та нар өмнөх жилийн хурлаараа энэ газрын тос, ураны асуудлуудаа яриагүй л байна гэсэн үг дээ. Тийм учраас одоо энэ асуудлыг хэлэлцэе, та саналаа томъёолоод бичиж байгаарай. Хэдүүлээ одоо ямарваа нэгэн асуудлыг ажил хэрэгч байдлаар тавьж байя. За одоо Цолмон энэ асуултад хариулъя.

Б.Болдбаатар: Урьд нь энэ асуудлыг зөндөө ярьдаг байсан.

Ш.Цолмон: Газрын тосны компаниудын хувьд тэр Ашигт малтмалын тухай хуулийн 48.10 гэсэн заалт хамаардаггүй. Эд маань ёстой сайн дураараа санаачилгын тайланг гаргаж ирсэн. Анх ганцхан Петрочайна дачин тамсаг ХХК санаачилгын тайланг гаргадаг байсан бол ажлын албанаас хэдэн хэдэн сургалт зохион байгуулсны дараа газрын тосны 13 компани тайлангаа гаргасан байгаа. Ураны компаниудын хувьд Вестерн проспектор, Арева, Төв азийн уран гэх зэрэг компаниуд тайлангаа гаргаад явж байна.

Б.Осоргарав: Групп компанийн хувьд уул уурхайтай холбоотой асуудлаар нь л нэгтгэлд оруулж явж байгаа. Гацуурт, М-Си-Эс гэх зэрэг групп компаниуд уул уурхайн чиглэлийн тусдаа охин компани байгуулсан байдаг. Тэр охин компаниудыг нь нэгтгэлд хамруулаад явж байгаа.

Л.Гансүх: Асуулт дууслаа. Одоо 3, 4-р асуудлыг сонссоны дараагаар тайлантай холбоотой санал хэлэх хүн байвал саналаа бэлдэж байгаарай. За одоо тайлан

гаргаагүй компаниуд, тэдгээрт тооцох хариуцлагын талаар Ашигт малтмалын газрын дарга Г.Алтансүх танилцуулна.

II. ХЭЛЭЛЦСЭН нь: ОҮИТБС-ын тайлан гаргаагүй компаниудын тухай танилцуулга, санал

Г.Алтансүх: ОҮИТБС-ын тайлан гаргаагүй компаниудын тухай судалж үзлээ. Тэгэхээр ашигт малтмалын тусгай зөвшөөрөл эзэмшигч нь Ашигт малтмалын тухай хуулийн 48.10 дугаар заалтын дагуу ОҮИТБС-ын тайлангаа ажлын алба болон Ашигт малтмалын газарт 2007 оноос эхлэн өгч эхэлсэн.

2007 онд нийт 1599 тусгай зөвшөөрөл эзэмшигчийн 65 нь буюу 4,1 хувь нь, 2008 онд 1881 тусгай зөвшөөрөл эзэмшигчийн 105 нь буюу 5,6 хувь нь, 2009 онд 1909 тусгай зөвшөөрөл эзэмшигчийн 135 нь буюу 7,1 хувь нь, 2010 онд 1907 тусгай зөвшөөрөл эзэмшигчийн 262 нь буюу 13,7 хувь нь, 2011 онд 1840 тусгай зөвшөөрөл эзэмшигчийн 283 нь буюу 15,4 хувь нь ОҮИТБС-ын тайлангаа гаргасан байна.

Хэдийгээр жилээс жилд тайлан гаргах компанийн тоо нэмэгдэж байгаа ч нийт компанийн 15,4 хувь нь ОҮИТБС-ын тайлангаа гаргаж байгаа нь хангалтгүй байна. Энэ нь хууль эрх зүйн орчин боловсронгуй бус, хангалтгүй байгаатай холбоотой гэж дүгнэж байна.

Тайлан гаргаагүй компанид тооцох хариуцлагын тухайд Ашигт малтмалын тухай хуулийн 66.1.2-д заасны дагуу албан тушаалтныг 100,000-500,000 хүртэлх төгрөгөөр, хуулийн этгээдийг 500,000-1,000,000 хүртэлх төгрөгөөр торгодог ба энэ үүргийг МХЕГ хүлээдэг.

Өмнөх жилүүдийг судлаад үзэхэд МХЕГ нь 2009 онд 41 аж ахуйн нэгжийг 31,5 сая төгрөгөөр, 2011 онд 3 аж ахуйн нэгжийг 2,5 сая төгрөгөөр торгосон байдаг юм байна. Бусад онуудад ямар арга хэмжээ авсан талаарх мэдээлэл бидэнд олдсонгүй.

2011 оны байдлаар 1840 аж ахуйн нэгж 3700 орчим тусгай зөвшөөрөл эзэмшиж байна. Тэгэхээр ОҮИТБС-ын 2011 оны тайланг эдгээрийн 15,4 хувь нь л гаргасан байна. Түрүүнд Ерөнхий сайд хэллээ. Ер нь тайлан гаргаж өгөх ёстой юмуу? Гаргаж өгөөгүй бол ямар хариуцлага тооцдог юм бэ? гэж асууж байсан. Санаачилга нь хэрэгжиж эхлээд 6 дахь жилийнхээ тайланг гаргаж байна. Энэ хугацаанд яахав тайлан гаргах компанийн тоо бага багаар нэмэгдэж байгаа ч, яг хууль эрх зүйн орчныг боловсронгуй болгох чиглэлээр тодорхой ажлууд хийгдээгүй харагдаж байна. Тэгэхээр бидний зүгээс ерөөсөө бүх компаниудыг тайлан гаргадаг болгохыг тулд хууль эрх зүйн орчныг бүрдүүлж өгөх хэрэгтэй гэсэн саналтай байна. Юуны түрүүнд Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах замаар тухайлбал, тэр хариуцлага тооцох заалт буюу торгуулийн хэмжээг нэмэгдүүлэх замаар, дараа нь тодорхой нөхцөл, шаардлагыг нэмж өгөх замаар дээрх асуудлыг шийдвэрлэх боломжтой гэж үзэж байна. Тэгээд хууль эрх зүйн орчныг боловсронгуй болгох чиглэлээр тодорхой саналуудыг ажлын албатай хамтраад Ашигт малтмалын газар гаргая гэсэн саналтай байна. /Танилцуулгыг хавсаргав./

Л.Гансүх: Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулъя гэхээр цаг хугацаа их орох гээд байна. Наана нь нэг акт гаргадаг ч юмуу өөрөөр зохицуулах боломж бий юу? Жишээлбэл, тайлангаа гаргаагүй бол ирэх жилийн уулын ажлын төлөвлөгөөг баталдаггүй ч юмуу тийм Сайдын тушаал гаргах гэх мэт хурдан шийдвэрлэх гарцууд байна уу?

Г.Алтансүх: Хариуцлага тооцоход хуулийн заалтыг баримтлана. Бид одоогийн байдлаар тайлан, төлөвлөгөөг авахдаа хуулийн заалтыг л баримталдаг. Нийтээр дагаж мөрдөх журам боловсруулахын тулд Үндэсний зөвлөл, ажлын хэсгийн хурлаар хэлэлцэх хэрэгтэй.

Л.Гансүх: Цолмонд энэ талаар судалсан зүйл байна уу?

Ш.Цолмон: Бидэнд судалсан зүйл байхгүй. Хуулиа л барьж явдаг.

Л.Гансүх: Тэгээд одоо яах юм. Бид нарын ажил ингээд л унаж байна шүү дээ.

Н.Дорждарь: Эрх зүйн орчин бүрдүүлэхэд чухал. Гэхдээ хурдан шийдвэрлэх нэг ийм арга зам байж болох юм. 1800 гаруй тусгай зөвшөөрөл эзэмшигч байна гэж байхад Засгийн газар өөрөө 500 гаруй компаниар л тайлангаа гаргаж байна. Татварын ерөнхий газарт тэр 1800 гаруй компани ямар нэгэн байдлаар бүртгэлтэй байгаа байх гэж бодож байна. Тиймээс Засгийн газар эхлээд бүх компаниудаар тайлангаа гаргадаг болмоор байна. Харин компаниудад санаачилгын тайланг гаргах талаар сурталчилгаагаа идэвхжүүлэх хэрэгтэй.

Л.Гансүх: Татварын ерөнхий газар хариулна уу. Яагаад 500 компанийг сонгож тайлангаа гаргасан юм бэ?

Б.Болормаа: Сангийн яамны Нягтлан бодох бүртгэлийн газрын ахлах мэргэжилтэн байна. Уул нь бол тэр 1840 компаниар тайлан гарах ёстой. Бид Татварын ерөнхий газраас хүлээж авсан мэдээллийг нэгтгэж Засгийн газрын тайланг гаргадаг. 2011 онд Засгийн газар тайлангаа 518 компаниар гаргасан. Гэтэл үүний 200-г нь аудитын нэгтгэлд оруулсан байна. Яагаад 518 компанийг бүгдийг нь аудитад оруулахгүй, 200-г нь сонгож авсан юм бол? Тэнд Ашигт малтмалын газар 1840 компани гэж яриад байдаг, Татварын ерөнхий газар 518 компанийг гаргаж өгсөн байна, аудитад 200 компани орсон байна. Эндээс үзэхэд хоорондоо уялдаагүй харагдаад байна. Үргэлжлүүлээд би 4-р асуудлаа танилцуулахад аудитын тайланд Сангийн сайдын 45-р тушаалын хэрэгжилт хангалтгүй байна гэсэн байсан. Энэ 45-р тушаалд ерөөсөө хандив авсан, хандив өгсөн талууд хандивыг ингэж бүртгэ л гэсэн журам байдаг. Түүнээс хандиваа бүртгээгүй бол ямар хариуцлага хүлээлгэх талаар журамд зааж өгөөгүй байна. Харин нягтлан бодох бүртгэлийн тухай хуулинд ажил гүйлгээгүй бол торгох тухай санкц бол байдаг. Тэгээд тэр аудиторчийн хэлж байгаагаар нэг нь өгсөн гээд, нэг нь аваагүй гээд байхад яг хэн дээр нь хариуцлага тооцох, хэнийг нь торгох нь тодорхойгүй байна. Тиймээс бид үүнийг сайн судлах хэрэгтэй байна.

Л.Гансүх: Байгууллага хооронд болон хувь хүн хооронд ийм зөрүү гарвал Авилгатай тэмцэх газар өгөхөд шалгана биз дээ.

Б.Болормаа: Жишээлбэл Эрдэс, баялаг, эрчим хүчний яаманд 2 сая төгрөгийн хандив өгсөн гэж байхад яам нь хүлээж аваагүй, ингээд зөрүү үүссэн гэж энэ тайлан дээр байна л даа.

Л.Гансүх: Бид өнөөдрийн хурлаараа их олон зүйлийг шинэчлэх шаардлага гарч байна. Өөр арга байхгүй. Бид асуудлыг шийдэх гэж энд байгаа учраас ямар нэгэн байдлаар гарцыг нь олох ёстой. Үнэхээр хуулинд нэмэлт, өөрчлөлт оруулах шаардлагатай бол үүнийг аль болох хурдан хийх талаас нь анхаарч ажиллая. Одоо Татварын ерөнхий газар саналаа хэл дээ. Уялдаа холбооны тухайд хэдүүлээ дотроо нэг журам гаргая. Жишээлбэл, хамгийн анхны мэдээллийг АМГ гаргаад ТЕГ өгнө, ТЕГ тэдгээртэй холбоотой мэдээллийг гаргаад компаниуд руу бичиг явуулдаг ч юмуу. Энэ асуудал дээр ялангуяа санаачилгын гишүүнээр олон жил ажилласан гишүүд саналаа сайн өгөөрэй.

Ш.Цолмон: Анх 2006 оны тайланг 64 компани л гаргаж байсан. Тэгээд бид тайлангаа гаргаарай гэсэн шаардлагыг тавихаар хайгуулын компаниуд бид олборлолт хийгээгүй учраас гаргахгүй гэдэг байсныг хайгуулын компаниудад зориулж 2 дугаар маягтыг гаргасан, газрын тосны компаниуд болохоор Ашигт малтмалын тухай хууль бидэнд хамаардаггүй гэсэн тайлбар тавьдаг байсан, тэгэхээр нь бид газрын тосны компаниудад зориулаад 3 дугаар маягтыг гаргаж өгсөн. Яахав ингэсний хүчинд тодорхой хэдэн компаниудыг гаргуулсан ч гэсэн бүгд хамрагдахгүй байна.

Д.Дамба: Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилга гэхээр нэр томъёоны хувьд хүртэл хайгуулын компаниудад хамааралгүй болчихоод байна л даа. Тэр 1800 компанийн ихэнх нь хайгуулын компаниуд байгаа даа. Яг олборлолт явуулдаг нь 400-500 компани байгаа.

Г.Чагнаадорж: Ашигт малтмалын газар, Татварын ерөнхий газар, Сангийн яам гэсэн энэ гурван байгууллагын уялдаа холбоо муу байна гэж бодож байна. АМГ нь 1840 компани байнаа гэж байхад 518 компаниар тайлангаа гаргасан байх юм. Төрийн ажил гэдэг чинь хоорондоо тоо мэдээллээ аваад л яг таг гаргаж болмоор юм шиг санагдаад байх юм.

Л.Гансүх: Таны санааг ойлголоо. Хурлын цагаа баримтлах үүднээс яг өнөөдрийн байдлаар асуудлыг шийдвэрлэж болохгүй бол Үндэсний зөвлөлийн хурлаа дахиад хуралдуулъя. За яахав Цөмийн энергийн газар, Газрын тосны газарт би үүрэг өгье. Харин АМГ-ын даргаас асууя. Энэ лиценз эзэмшигч бүх компанийг тайлан гаргуулж чадах уу? Тайлан гаргуулахын тулд та юу хийж чадах вэ? Гэтэл та эцсийн цэг нь Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хэрэгтэй гээд байх юм. Ашигт малтмалын газрын даргын тушаалаар шийдэж болохгүй юмуу?

Г.Алтансүх: Бид журмандаа ОҮИТБС-ын тайланг гаргаж бай гэж заагаад өгч болно оо. Гэхдээ хариуцлага тооцох асуудал нь хуулиараа л байдаг. Одоогийн хуулиар

тайлан гаргаагүй бол 1 сая төгрөгөөр л торгох боломжтой. Гэтэл уул уурхайн компаниудад 1 сая төгрөг бол сонин биш л байхгүй юу. Тэгэхээр миний хувьд хуулиндаа л өөрчлөлт оруулах хэрэгтэй гэсэн саналтай байна.

Л.Гансүх: Тайлан гаргахгүй бол лицензийг нь цуцалдаг эрх та нарт байхгүй юм уу?

Г.Алтансүх: Бидэнд тийм эрх байхгүй ээ.

Л.Гансүх: Хайгуулын лиценз авчихаад хэдэн жил хайгуул хийхгүй байж болдог юм бэ?

Г.Алтансүх: Хайгуулын ажлын төлөвлөгөө нь 3 жилээр нийтдээ 9 жил байгаа.

Л.Гансүх: Хэдий хугацаанд хайгуулын ажил хийхгүй байж болох юм бэ?

Г.Алтансүх: Өмнөх нь жил хайгуулын ажлаа хийгээгүй бол дараа жил нь цуцалдаг.

Л.Гансүх: Тэгэхээр та нар жилд дор хаяж нэг удаа тэр хайгуулын компаниудтай холбогддог юм байна шүү дээ.

Г.Алтансүх: Гэхдээ ОҮИТБС-ын тайлан заавал гарга гэсэн хуулийн заалт байхгүй учир хариуцлага тооцож болохгүй байна. Одоо бол бид Ашигт малтмалын тухай хуулийн 48.10 гэсэн заалтыг буюу "тухай жилд улсад төлсөн татвар, төлбөрийн хэмжээгээ дараа жилийн 1-р улиралд багтаан нийтэд ил тод мэдээлнэ" гэсэн үг хэллэгийг ашиглаад л тайлан гаргуулдаг. Үүнийг илүү тодорхой болгох хэрэгтэй.

Б.Баттөмөр: За тэр 1840 компани татварын газар бүртгэлтэй. АМГ болон ТЕГ нь 2011 оноос хойш мэдээллээ солилцдог болсон. 2010 онд ТЕГ нь 517 компаниар, 2011 онд 1537 компаниар тайлангаа гаргаж Сангийн яаманд өгсөн. Сангийн яам үүнээс 518 компанийг нь нэгтгэсэн гэж ойлгож байна. Нөгөө талаас 2011 онд 301 компани ил тод байдлын тайлангаа гаргаж өгснөөс 40 сая төгрөгийн татвар, төлсөн 200 компанийг нь аудитын нэгтгэлд оруулжээ.

Л.Гансүх: 1840 компаниас 1537 компанийг нь гаргаж өгчээ. Тэгвэл үлдэж байгаа 200 гаруй компанид ямар арга хэмжээ авах ёстой вэ?

Б.Баттөмөр: Бидний хувьд ямар нэгэн арга хэмжээ авах эрх байхгүй.

Н.Дорждарь: Засгийн газар өөрийнхөө тайланг компаниудаас ямар ч хамааралгүйгээр гаргаж байгаа. ТЕГ 1537 компанийн тайланг гаргаж өгч байхад Сангийн яам яагаад 1000 компанийг нь хасаад 518 компаниар тайлангаа гаргасан юм бэ? Энд л асуудал байна. Түүнээс компаниудын асуудал тусдаа.

Б.Болормаа: Сангийн яам 518 компанийн тайланг хүлээж авч, нэгтгэсэн юм байна.

Л.Гансүх: Санаачилгын мөн чанар нь Засгийн газрын тайлан, компанийн тайланг хооронд нь тулгахад нийлж байх ёстой л гэж ойлгож байна. Тэгэхээр манай иргэний нийгмийнхан зөвхөн Засгийн газрынх байвал болоо, нөгөө тал нь хамаагүй гэж байна гэж ойлгож болох уу?

Н.Дорждарь: Үгүй ээ. Тэгж хэлээгүй. Эхний удаад Засгийн газар нь тайлангаа бүх компаниар гаргавал нөгөө талдаа шууд зөрүү үүснэ. Үүнийг аудит шалгаад явах учиртай. Тэгэхгүй бол аль аль талдаа тайлангүй бол түүнийг илрүүлэх боломжгүй болох юм.

Л.Гансүх: Аудитын байгууллага нягтлана гэхээр яах юм?

Б.Осоргарав: 2011 оны нэгтгэлд 58 компани тайлангаа ирүүлээгүй байсныг хойноос нь олж уулзаад, нөхөж гаргуулсан.

Л.Гансүх: За яахав 58 компанийг нөхөж гаргуулж болдог юм байж. 1800 компанийн араас яаж хөөцөлдөх үү? Хэдэн төгрөгөөр аудитын ажил хийлгүүлж байгаа билээ. Миний хувьд яаж тэр 1800 компанийг бүгдийг нь тайлан гаргуулах вэ гэж бодож байна.

Н.Дорждарь: Тэр 1800-аас материаллаг босгоороо ихэнх нь аудитад орохгүй байх. Гол нь томоохон төлбөр төлсөн материаллаг төлбөртэй компанийг аудитын байгууллага шалгах ёстой.

Л.Гансүх: Төрийн байгууллагын хувьд бүх компаниар тайлан гаргахад ямар ч асуудал байхгүй. Би үүнд огт эргэлзэхгүй байна. Харин тэр тайлангаа ирүүлэхгүй байгаа компанийг яах юм бэ? Лиценз гэдэг чинь зүгээр нэг цаас юм уу? Дуртай нь тайлангаа гаргадаг, дургүй нь тайлангаа гаргахгүй байж болдог ийм байж болохгүй.

Н.Дорждарь: Би таньтай санал нэг байна.

Г.Цогт: Хайгуулын ч бай, ашиглалтын ч бай лиценз эзэмшигч компаниуд уулын ажлын, хайгуулын ажлын төлөвлөгөөгөө АМГ-т өгч байгаа. Харин Алтансүх даргын хэлж байгаагаар ОҮИТБС-ын тайлан гаргаагүй тохиолдолд хариуцлага тооцох сайн заалт алга байна гэж байна. Харин ямар мэдээллийг аль төрийн байгууллагаас авах вэ гэдэг нь тусдаа асуудал байх. Жишээлбэл, хандив тусламжийн талаарх мэдээллийг АМГ гаргаж өгдөг тайлангийн маягтад оруулах нь утгагүй болно. Энэ бол татварын байгууллага дээрээ л байж байх нь зүйтэй. Нөгөөтэйгүүр, хандив дээр зөрүү үүссэн гэж байна. Жишээлбэл, Шивээ хүрэнгийн боомт дээр 3 компани хамтраад 1 тэрбум 800 сая төгрөгөөр нүүрсний гарц барьж өгөх болсон. Гэтэл тэнд гааль, хилийн цэрэг, мэргэжлийн хяналт, гадаадын харъяат гэх зэрэг олон байгууллага байж байдаг. Яг хэнд нь барьж өгсөн нь ойлгомжгүй, компаниас бол хандив гээд бүртгэсэн байдаг, аль

байгууллага дээрээ бүртгэх нь ойлгомжгүй ийм тодорхойгүй нөхцөлүүд амьдрал дээр гардаг.

Л.Гансүх: За одоо хандивын асуудлаар 4-р асуудлыг Б.Болормаа танилцуулна.

III. ХЭЛЭЛЦСЭН нь: Сангийн сайдын 45 дугаар тушаалын хэрэгжилтийн байдал, санал

Б.Болормаа: Аудитын байгууллагын тайлантай танилцахад энэ 45-р тушаалыг аль аль тал нь мөрдөхгүй байгаа юм байна гэж ажиглагдаж байна. Хоёрдугаарт, энэ тушаалыг мөрдөөгүй тохиолдолд ямар хариуцлага тооцох талаар журамд заагаагүй учраас бидэнд хариуцлага тооцоход хүндрэлтэй байна. Тийм учраас энэ тушаалыг Сангийн яам дахиж шинэчлэн батлах нь зүйтэй гэсэн саналтай байна. Гуравдугаарт, ханшийн зөрүүнээс болж зөрүү үүсдэг, эсвэл хандиваа бүртгэхдээ мөнгөн дүнгээр зөрүүлснээс зөрүү үүсдэг юм байна. Үүн дээр анхаарах хэрэгтэй юм байна. За дараа нь хандив авсан мөртлөө бүртгээгүй тохиолдолд үүнийг хууль, хяналтын байгууллага нь шалгаад нотлогдвол бид Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн дагуу холбогдох албан тушаалтныг нь хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 5 дахин нэмэгдүүлсэн хэмжээгээр буюу 702,000 төгрөгөөр торгох хуулийн санкц байгаа.

Л.Гансүх: За үүнтэй холбоотойгоор асуух асуулттай хүн байна уу?

Б.Болдбаатар: М-Си-Эс Петро Монголиа гэдэг компани Газрын тосны газарт хүслийн ундаа 408 ширхэгийг, Чингис архи 60 ширхэгийг, Tiger, Сэнгүр пиво 200 ширхэгийг хандивласан гэжээ. Тэгэхээр Кока кола гэдэг компани хандив өгөөд байгаа юмуу эсвэл энэ Петрочайна нь хандив өгөөд байгаа юмуу? Хандиваа нээлттэй мэдээлж байгаа нь сайшаалтай, гэхдээ газрын тосны газарт ингэж хандив өгч байгаа нь авилга өгөөд байгаа юмуу, хандив өгөөд байгаа юмуу гэж харагдаж байна.

Л.Гансүх: Петрочайна нь дэлгүүрээс аваад өгсөн л байх л даа.

С.Мэргэнсод: Саяны энэ кола хүслийн ундаа гээд хандивууд Петрочайна дайчин тамсаг ХХК-тай ямар ч холбоогүй шүү.

Б.Болдбаатар: Хамаагүй, хамаагүй. Буруу хэлсэн байна. М-Си-Эс Петро Монголиа гэдэг компани шүү.

Л.Гансүх: За бидэнд шийдвэрлэх шаардлагатай нилээн олон асуудлууд байна. Эргээд ажлын хэсгийн хурлаараа эдгээр асуудлуудыг сайн хэлэлцэж байгаад Үндэсний зөвлөлөө дахин хуралдуулая. Нэгэнт бид хугацаатай хуралдаж байгаа учраас энэ бүх асуудлууд дээр гаргах шийдвэрээ нягтлаад явъя. Шийдвэрийн төслийг би уншаад явъя та бүхэн саналаа хэлээрэй.

Ш.Цолмон: Тэр 3 дугаар шийдвэрийн төслийн хувьд Олон улсын шаардлагадаа компанийн болон Засгийн газрын тайлан нь аудитаар баталгаажсан байх ёстой гэж

заасан байдаг. Үүнийг хэрэгжүүлэх зорилготойгоор дотооддоо ийм хамтарсан тушаал гаргах шаардлагатай байгаа.

Л.Гансүх: 5 дахь шийдвэрийн төслийн хувьд Санаачилгын тайланг жилдээ нэг удаа нэгтгэхэд зөрүү үүсээд хүндрэлтэй байгаа юм чинь улирал бүр ингэж тооцоо нийлнэ гэж байхгүй байх. Тиймээс үүнийг хасаарай. Бусад нь бол болж байна. Үүн дээр нэмээд саяны бидний ярьсан Сангийн сайдын 45-р тушаалыг шинэчлэх тухай нэмж оруулъя. Дараа нь АМГ, ТЕГ хоёр хамтраад лиценз эзэмшигч бүх компаниудаар тайланг гаргаж Сангийн яаманд хүлээлгэж өгөх, Сангийн яам нь яг тэр хүлээлгэж өгсөн компаниудаар Засгийн газрын тайланг гаргаж байх тухай шийдвэрийн төсөл найруулж оруулъя. Дээр нь ЦЭГ, ГТГ нэмж оруулах хэрэгтэй. За одоо тайлан гаргаагүй компаниудыг яах вэ? Бүх компаниуд тайлан гаргадаг байх хууль, эрх зүйн орчинг 2013 онд багтаан бүрдүүлэх чиглэлээр Үндэсний зөвлөлийн гишүүд санаачилгатай ажиллах гэж томъёолоод өөрсдөдөө үүрэг өгье дөө.

Н.Дорждарь: Тэр тайлан гаргаагүй компаниудыг 1 сая хүртэлх төгрөгөөр торгодог одоогийн энэ хуулийн заалтаа МХЕГ хэрэгжүүлэх ёстой байх аа. Түүнчлэн тайлан гаргаагүй гэдэг нь нэр хүндтэй холбоотой асуудал учраас үүнийг интернэт, вэбсайтаар зарлах нь зүйтэй байх.

Л.Гансүх: Энэ бол тэр 2 дугаар заалтаар шийдэгдэх байх гэж бодож байна. Дээр нь Авилгатай тэмцэх газар өгч болно гэж нэмж болох л юм.

Н.Баярсайхан: Үндэсний зөвлөлөөс өгч болох уу?

Ж.Наранбаатар: Иргэн ч өгч болно. Төрийн байгууллага, албан тушаалтан нь албан тушаалаа урвуулан ашигласан л байвал манайх шалгана.

Л.Гансүх: Хэдүүлээ үүнийг шат шатандаа өгье гэсэн нь өгөөд явъя. Өөр нэмэх юм байна уу?

Б.Батболд: Тайланг олон нийтэд хүргэх асуудлын тухайд жишээлбэл Төв аймагт үйл ажиллагаа явуулдаг компанийн мэдээллийг Төв аймагт оршин суудаг иргэдэд нь хүргэдэг ийм механизмыг бүрдүүлмээр байгаа юм. Ганцхан вэбсайт дээр тавихаар орон нутгийн иргэд тэр болгон үзэж чадахгүй байгаад байна.

Л.Гансүх: Үүнийг 8-р заалтаараа явъя. Тайланг олон талт оролцогчдоор хэлэлцүүлэхийг гурван талын төлөөлөлд даалгасан байна. Тайланг орон нутгаар бас гаргасан байгаа учраас та бүхэн энэ тайлангаа бариад л орон нутгаар явах хэрэгтэй. Ажлын хэсэг хуралдахаар санал байвал танилцуулаарай.

За дээр нь саяны гарсан шийдвэрүүдийг хэрэгжүүлэх зорилгоор Ажлын хэсэг хуралдаад ямар үр дүнд хүрснээ эргээд Үндэсний зөвлөлд танилцуулах гээд нэмж оруулъя. Үүнийг харин ямар хугацаанд гэх вэ? Тэгэхгүй бол ажил хийдэггүй гээд л бие биенээ шүүмжлэхээ больё. Би бол хоёр л юм яриад байгаа. Нэгдүгээрт, бүгдээрээ ажлаа хийдэг болцгооё. Хоёрдугаарт, дотроо асуудлуудаа сайн хэлэлцээд нэг

ойлголтод хүрчихээд гараад бүгд нэг л байр суурьтай байна шүү. Түүнээс биш би иргэний нийгмийн байгууллага, зад шүүмжлээд өглөө гээд л, эсхүл би бизнесийн байгууллагынхаа эрх ашгийг сайн хамгааллаа гээд, тэгээд явж явж нөгөө төрийн байгууллага нь хэрэгт ороод дуусдаг ийм юм байхгүй шүү. Бүгдээрээ л ажлаа тэгш хуваарилж хийнэ шүү. За тэгээд хугацаагаа тохиръё. 2013 оны 1-р улиралд багтаагаад Үндэсний зөвлөлд эргээд танилцуулахыг Л.Гансүх, Ш.Цолмон хоёрт даалгая.

За тэр тайлан гаргаагүй компаниудад хариуцлага тооцох тухайд хууль эрх зүйн орчинг судалж, 2013 оны 1-р улиралд багтаан санал боловсруулж ирэхийг АМГ болон ажлын албанд даалгая.

Сангийн сайдын 45-р тушаалын тухайд өөрчлөлт оруулж, шинэчлэхийг Сангийн яам, Ажлын хэсэгт даалгая. За ингээд тайлантай холбоотой асуудлуудаа ингэж шийдвэрлэхээр тогтоё.

ШИЙДВЭРЛЭСЭН нь:

1. Их Британийн Харт Нойрс лтд болон Монголын Улаанбаатар аудит корпораци ХХК-ийн хамтарсан консорциумын хийж гүйцэтгэсэн Монгол Улсын ОҮИТБС-ын зургадугаар буюу 2011 оны нэгтгэлийн тайланг Үндэсний зөвлөлийн хуралдаанаар хэлэлцэн дэмжээд, гишүүдийн гаргасан саналыг тусган батлав.

2. Монгол Улсын ОҮИТБС-ын зургадугаар буюу 2011 оны нэгтгэлийн тайланг болон түүний хураангуй хувилбарыг ОҮИТБС-ын ажлын алба, Сангийн яам, Уул уурхайн яам, Монголын Уул уурхайн үндэсний ассоциаци, Нээлттэй нийгэм форумын цахим хуудсуудад байршуулж, нийтэд ил тод мэдээлэхийг дээрх байгууллагуудын удирдлагуудад үүрэг болгов.

3. Монгол Улсын ОҮИТБС-ын зургадугаар буюу 2011 оны нэгтгэлийн тайланг ОҮИТБС-ын Олон улсын удирдах хороонд илгээхийг ОҮИТБС-ын ажлын албаны зохицуулагч Ш.Цолмонд даалгав.

4. Монгол Улсын ОҮИТБС-ын зургадугаар буюу 2011 оны нэгтгэлийн тайланг олон талт оролцогчдын уулзалтаар хэлэлцүүлэхийг Үндэсний зөвлөлийн гурван талын төлөөлөл (Уул уурхайн сайд Д.Ганхуяг, Монголын Уул уурхайн үндэсний ассоциацийн ерөнхийлөгч Д.Дамба, Нээлттэй нийгэм форумын гүйцэтгэх захирал П.Эрдэнэжаргал)-д үүрэг болгож, хэлэлцүүлэг зохион байгуулахад дэмжлэг үзүүлж ажиллахыг ОҮИТБС-ын ажлын албаны зохицуулагч Ш.Цолмонд даалгав.

5. Монгол Улсын ОҮИТБС-ын зургадугаар буюу 2011 оны нэгтгэлийн тайлангийн хэвлэлийн бага хурал зохион байгуулж, нийтэд мэдээлэхийг Засгийн газрын хэвлэл мэдээллийн алба, ОҮИТБС-ын ажлын албанд үүрэг болгов.

6. Их Британийн Харт Нойрс лтд болон Монголын Улаанбаатар аудит корпораци ХХК-ийн хамтарсан консорциумтай байгуулсан гэрээт ажлын үлдэгдэл

төлбөрийг тайлангийн англи хэл дээрх хувилбарыг хүлээж авсны дараа шилжүүлэхийг ОҮИТБС-ын ажлын албанд зөвшөөрөв.

7. Тайлангаар илэрсэн 622,4 сая төгрөгийн шийдэгдээгүй зөрүүг зөрүү бүрээр нягтлан шалгах, холбогдох албан тушаалтнуудад хариуцлага тооцох талаархи санал, арга замын талаархи асуудлыг Ажлын хэсгийн хуралдаанаар хэлэлцүүлэхийг Ажлын хэсгийн ахлагч, нарийн бичгийн дарга нарт даалгав.

8. Компанийн болон Засгийн газрын жил бүрийн ОҮИТБС-ын тайланг тухайн компанийн аудитын байгууллагаар болон Үндэсний аудитын газраар баталгаажуулах тухай журам боловсруулж, нийтэд мэдээлж ажиллахыг ОҮИТБС-ын Ажлын хэсэг, Сангийн яамд үүрэг болгов.

9. ОҮИТБС-ын Засгийн газрын 2012 оны тайланг, цаашид жил бүрийн тайланг Ашигт малтмалын газар, Газрын тосны газар, Цөмийн энергийн газраас ирүүлсэн мэдээлэлд тулгуурлан тусгай зөвшөөрөл эзэмшигч бүрээр нэгтгэн гаргахыг Үндэсний татварын ерөнхий газар, Сангийн яаманд үүрэг болгов.

10. Газрын тос, уран, ашигт малтмалын лиценз эзэмшигч бүх компаниуд ОҮИТБС-ын тайланг тогтмол гаргаж байх нөхцөлийг бүрдүүлэх эрх зүйн акт, журам боловсруулах чиглэлээр анхаарч ажиллахыг Үндэсний зөвлөлд үүрэг болгов.

11. 2013 оноос эхлэн ОҮИТБС-ын тайланг цахим хэлбэрээр авах ажлыг зохион байгуулж, холбогдох талуудтай хамтран ажиллахыг ОҮИТБС-ын ажлын хэсэг, Ашигт малтмалын газар, Үндэсний татварын ерөнхий газар, Сангийн яамд үүрэг болгов.

12. Дээрх үүрэг болгосон асуудлуудыг ОҮИТБС-ын ажлын хэсгийн хурлаар нарийвчлан хэлэлцэж, үр дүнг 2013 оны 1 дүгээр улиралд багтан Үндэсний зөвлөлд танилцуулахыг ОҮИТБС-ын ажлын хэсгийн ахлагч Л.Гансүх, ажлын албаны зохицуулагч Ш.Цолмон нарт үүрэг болгов.

13. ОҮИТБС-ын тайлан гаргаагүй компаниудад хариуцлага тооцох журмын төслийг 2013 оны 1 дүгээр улиралд багтаан боловсруулж, Үндэсний зөвлөлд танилцуулахыг Ашигт малтмалын газар (Г.Алтансүх), ОҮИТБС-ын ажлын алба (Ш.Цолмон)–д үүрэг болгов.

14. Сангийн сайдын 45 дугаар тушаалыг 2013 оны 1 дүгээр улиралд багтаан шинэчилж, шинэчилсэн журмын төслийг Үндэсний зөвлөлд танилцуулахыг Сангийн яаманд үүрэг болгов.

IV. ХЭЛЭЛЦСЭН нь: ОҮИТБС-ын тайлангийн маягтуудыг шинэчлэх тухай

Л.Гансүх: За маягтанд өөрчлөлт оруулах асуудлыг бид ажлын хэсгийн хурлаараа 2 ч удаа хэлэлцсэн. Танилцуулгыг та бүхэнд хүргүүлсэн байгаа. /Танилцуулгыг хавсаргав./ За үүнтэй холбоотойгоор та бүхэнд асуух асуулт байна уу?

Б.Болдбаатар: Бусад гэсэн нэг мөр байсныг байхгүй болгосон байна.

Л.Гансүх: Бусад гээд байна. Дотор нь торгууль, нөхөн төлбөр орсон байна.

Б.Болдбаатар: Тодорхой болчихсон байна л даа. Уул нь бусад дотор бусад гэж баймаар байгаа юм.

Л.Гансүх: Тодорхой байхгүй бол одоо бид 1800 компанийн тайланг авахаар тэр болгонд тайлбарлаад явж байх зав, цаг байхгүй л дээ.

Д.Цэрэнжав: Тайлангийн маягтыг бид нилээн хэлэлцсэн. Гэхдээ энэ хуралдааны материалуудыг уншихаар бусад дотор бусад гэсэн хэсэг байх хэрэгтэй юм шиг санагдлаа. Амьдрал өөрөө баялаг юм чинь энэ хугацаанд шинэ хууль журам гардаг ч юмуу, эсвэл одоо орон нутаг, компани хоёр хамтраад соёлын өв хамгаалах ч юмуу ямар нэгэн зардал гаргалаа гэхэд үүнийг тайлагнах мөр байхгүй болчих вий гэж бодож байна. Тийм учраас улсын төсөвт төлсөн дээр, орон нутагт төлсөн дээр, хандив дэмжлэгийн хэсэг дээр бүгд дээр нь бусад гэсэн заалт нэмж өгье.

С.Мэндсайхан: Би танилцуулсан асуудлуудтай холбоотойгоор олон асуулт асууя гэж байсан боловч тэдгээр асуудлууд нь хоорондоо холбоотой болохоор сонсоод суусаар байтал хурал маань өндөрлөх гээд байна. Тиймээс саналаа хэлээд явъя. Миний хувьд Үндэсний зөвлөлд 4 дэх жилдээ орж ажиллаж байна. Энэ хугацаанд санаачилгын ажил маань жил ирэх тусам ахиц дэвшил гаргаж байгаа нь харагдаж байна. Ялангуяа 2012 онд 2011 оны тайланг хэлэлцэж байна гэдэг нь маш том ахиц юм. Урьд нь бид хоёр гурван жилийн өмнөх тайланг яриад, хэлэлцээд, батлах гээд сууж байдаг байсан. За өнөөдөр Үндэсний зөвлөлийн шинэчилсэн бүрэлдэхүүн хуралдаж байна. Хурал яг 5 цагтаа эхэлж байгаагаас эхлүүлээд шинэлэг зүйлүүд ажиглагдаж байна.

За олборлох үйлдвэрлэл эрхлээд тухайн компани улсад тэдэн төгрөгийн татвар төлжээ гэж мэдээлээд, нөгөө талаас улс нь тэднээс ийм орлого хүлээж аваад ийм зүйлд зарцуулсан юм шүү гээд хариу мэдээлэл бас хийдэг ийм хоёр тал харилцан бие биендээ хүндэтгэлтэй хандаж, мэдээлдэг байхад энэ санаачилгын гол утга учир оршиж байгаа юм болов уу. Тэгэхгүй бол компани нэг их олон газар мэдээ тайлан өгдөг, тэгээд тэрэндээ түүрддэг, нөгөө талаас тэднийг тайлан гаргахад нь шахаж дарамталдаг байж болохгүй юм. Тиймээс Үндэсний зөвлөлд харилцан бие биендээ хүндэтгэлтэй ханддаг талаас нь асуудлыг хараасай гэж уриалах байна.

Маягттай холбоотойгоор энэ олон байгууллагын авч буй мэдээллийг нэг болгох хэрэгтэй. Нэгтгэлээр ямар ч зөрүү үүсдэггүй тийм төлбөр, татваруудыг тайлагнуулахгүйгээр илүү зөрүү үүсдэг тэр татвар, төлбөрүүдийг хянаж шалгах чиглэлээр ажиллах, бараг Засгийн газар талаасаа тайланг бүрэн гаргуулаад зөрүү үүсдэг төлбөрүүдийг шалгах чиглэлээр ажиллавал санаачилгын нэгтгэлийн ажил илүү хөнгөн болох болов уу гэж бодож байна. Статистикийн байгууллага нь маш олон

төрлийн мэдээллийг хянаж, нэгтгэж нийтэд мэдээлдэгийн хувьд, маягт баталдагийн хувьд санаачилгын маягт нь арай түүхий байна уу гэж бодож байна.

За дээр нь ер нь хуралдаанаар хэлэлцсэн асуудлаа амьдрал дээр хэрэгжүүлдэг болохын тулд энэ хуралдаанд оролцдог байдлаа өөрчилмөөр байна. Тухайлбал, Үндэсний зөвлөлийн хурал даргалагч Ерөнхий сайд маань хурлаа нээгээд гараад явдаг, орлогч дарга Уул уурхайн сайд нь орж ирээд гараад явдаг, ялангуяа төрийн байгууллагуудын хуралд орж ирээд гараад явдаг, хуралдаанд өөрөө биечлэн оролцдоггүй энэ байдлыг болих хэрэгтэй. Нэг байгууллагаас гэхэд нэг ирэхэд л газрын дарга сууж байдаг, нэг ирэхэд л ахлах мэргэжилтэн сууж байдаг. Тэгээд хурлаар хэлэлцсэн мэдээллийг бүрэн авдаг ч юмуу үгүй ч юмуу. Үүнийг бүр журмандаа оруулж өгөх хэрэгтэй гэсэн саналтай байна.

Эцэст нь хэлэхэд тэр хандив авсан, өгсөн байгууллагуудын талаарх мэдээллийг жижиг тийм ном, товхимол болгож бэлдээд нийтэд мэдээлээд байвал хандивын асуудал цэгцрэх байх гэж бодож байна. 2012 оноос төрийн байгууллагууд хандив авдаггүй болно гэсэн тул энэ асуудал цэгцрэх байх. За тэгээд цаашид Статистикийн байгууллага идэвхтэй оролцоно гэдгээ илэрхийлмээр байна.

Л.Гансүх: Өөр санал байна уу?

Б.Болдбаатар: Уул уурхайтай холбоотойгоор маш олон соёлын өв, археологи, палеонтелогийн олдворууд устсан байдаг юм байна лээ. Тиймээс бусад гэж байх нь зүйтэй гэж бодож байна.

Л.Гансүх: Бусад дотор бусад гэж хийлгэх гээд байгаа юм уу? Та нарын нэг л хасая гээд л хассан биш билүү. Харин тэр ойгоос хэрэглээний мод, түлээ бэлтгэх зардал гэдгийг ярьж ярьж хасая гэсэн байсан чинь үлдээчихсэн байх юм. Хэн энийг үлдээсэн юм? Санал хураагаад шийдсэн зүйлийг маань бичиж байгаа хүн нь ингээд үлдээгээд байгаа бол протоколоо л дахиж үзэх хэрэг болох нь байна.

Ш.Цолмон: Хасна гэж байгаад хассан бүх татвар, төлбөрүүдээ иргэний нийгмийн байгууллагууд мэдээллээ аль болох бүрэн авч, нийтэд мэдээлэх үүднээс заавал тайлагнах хэсгээс сайн дураар тайлагнах хэсэг рүү шилжүүлэе гэдэг санал дэвшүүлээд, та зөвшөөрөөд ингээд сайн дурын хэсэгт үлдээсэн байгаа. Сайн дурын хэсэгт байгаа мэдээллүүдийг компани тайлагнасан ч болно, тайлагнахгүй байсан ч болно.

Л.Гансүх: За тэгвэл тэр бусад гэдгийг хаана оруулах юм бэ?

Н.Дорждарь: Бусад гэсэн хэсэг байхгүй тохиолдолд шинээр ямар нэгэн хууль гараад төлбөр төлөх боллоо гэхэд тэр болгонд маягт өөрчлөөд байх нь түвэгтэй. Тиймээс татвар дээр ч, төлбөр дээр ч бусад гэсэн хэсэг байх ёстой байх.

Л.Гансүх: Тэгвэл тэр ногдол ашиг дээр ч гэсэн байх ёстой гэсэн үг үү?

Н.Дорждарь: Эсвэл заавал тайлагнах хэсэгт нэгийг, сайн дураар тайлагнах хэсэгт нэгийг оруулж өгье.

Л.Гансүх: Өмнө нь бид маягт хэлэлцэхэд энэ сайн дурын гэсэн хэсгийг оруулж ирээгүй. Хараагүй болохоор гайхаад байна л даа. Тэгэхээр энэ маягтаа Статистикийн С.Мэндсайхан даргад өгч хянуулая. Харин хугацаа заая. 7 хоногийн дотор та энэ маягтыг хянаарай. Харин тэр бусад гэсэн хэсгийг хаана нь оруулахаа С.Мэндсайхан дарга өөрөө шийдээрэй. Энэ эрхийг нь хэдүүлээ өгье. За дараагийн асуудалдаа оръё.

ШИЙДВЭРЛЭСЭН нь: 1. ОҮИТБС-ын тайлангийн маягтуудыг Үндэсний зөвлөлийн гишүүдийн гаргасан саналыг тусган шинэчлэн батлахыг Үндэсний Статистикийн Хороо (С.Мэндсайхан)-д зөвшөөрөв.

V. ХЭЛЭЛЦСЭН нь: Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилгыг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, хянан зохицуулах үүрэг бүхий Үндэсний зөвлөлийн ажиллах журмыг шинэчлэн батлах тухай

Ш.Цолмон: Журмыг Засгийн газар ахлах референт Э.Сумъяа танилцуулах ёстой байсан боловч албан томилолттой байгаа тул миний бие танилцуулж байна. Журмын төслийг та бүхэнд тараасан байгаа. Онцлох зүйл гэвэл өнөөг хүртэл Үндэсний зөвлөлийн хуралдаан танхимын хэлбэрээр явагдаж ирсэн, үүнийг зарим тохиолдолд цахим хэлбэрээр явуулах заалт оруулж өгсөн байгаа. Оролцогч гурван талын ахлагч нарыг томилж өгсөн байгаа.

Л.Гансүх: Журамтай холбоотойгоор асуух асуулт байна уу?

Б.Батболд: Үндэсний зөвлөл, ажлын хэсгийн хуралд суугаад ажиглаад байхад төрийн байгууллагуудын дарга нар нь нэг орны хүнээ хуралд суулгадаг. Тэгээд нөгөө хүн нь ямар ч мэдээлэлгүй орж ирдэг, асуултад хариулдаггүй, очоод дарга даа ямар асуудал хэлэлцсэн талаар тайлагнадаггүй юм шиг байгаа юм. Дараа нь дарга нь өөрөө хуралдаа суухаар өмнөх асуудлаа мэддэггүй. Ийм байдал ажиглагдаад байна. Тиймээс даргын эзгүйд ямар хүн орлож суух юм, мэдээллээ хэрхэн дамжуулах гэдгийг журмандаа сайн тусгаж өгөхгүй бол энэ байдал дахиад л гарах вий гэж бодож байна.

Л.Гансүх: Энэ журман дээр хуралдааныг гурван тал ээлжилж даргална, хуралдааныг цахим хэлбэрээр зохион байгуулж болно гэх мэт шинэ заалтууд орж ирсэн байгаа. Харин яг хариуцлага тооцно гэхээр гурван талыг нэгдсэн байдлаар хариуцлага тооцно гэж байхгүй. Та бол төрийн захиргааны дарга нар хуралдаа ирэхгүй тохиолдолд хэн орлож ирэхийг зааж өг гээд байх шиг байна. Тэгвэл жишээлбэл та хуралдаа ирэх боломжгүй болсон тохиолдолд таныг хэн орлох вэ?

Б.Батболд: Би жишээ нь ирэх боломжгүй болвол надад орлогч гэсэн хүн байхгүй учраас бичгээр саналаа хүргүүлнэ. Оронд нь хүн ирдэг байдлыг болиулмаар байна.

Л.Гансүх: Нэг бол өөрөө биечлэн ир, үгүй бол хэн ч битгий ир гэх юм уу? С.Мэндсайхан дарга саналаа хэлэх үү. Энэ яах ёстой юм бэ?

С.Мэндсайхан: Ер нь бол аливаа нэг байгууллагын дарга нэг орлогчтой байх ёстой. Харин тэр оролж ирж байгаа хүн нь шийдвэр гаргах түвшний хүн байна. Амьдрал дээр дарга, орлогч хоёр хоёулаа байхгүй байна гэж байхгүй л дээ. Тиймээс ингээд шийдчих боломжтой байх. Хурлын ирцийн хувьд хурал зохион байгуулж байгаа ажлын алба мэдээллээ сайн аваад жишээлбэл, энэ энэ байгууллагаас ирнэ, ирэхгүй, ирц хүрнэ, хүрэхгүй гэж тооцоолоод статистикаас С.Мэндсайхан дарга ирэхгүй тохиолдолд бичгээр саналыг нь аваад ингээд явах ёстой.

Л.Гансүх: Дүрмэнд шууд тэр орлоно гэж заах нь бас учир дутагдалтай л даа. Тиймээс ёс суртахууны хувьд гишүүд аль болох биечлэн оролцохыг хичээе. Энэ бол цэвэр ёс суртахууны асуудал л даа. Манай зөвлөл нь төрийн захиргааны байгууллага биш л дээ. Гурван талын төлөөлөлтэй зөвлөл. Тиймээс хэн нэгэн гишүүн ирэхгүй бол яах вэ гэж бодох хэрэгтэй.

Н.Дорждарь: Нэг санал байна. Ирц бүртгэж байгаа юм чинь, хуралдааны тэмдэглэлээс гадна ирцийн бүртгэлийг вэбсайт дээрээ тавих хэрэгтэй.

Л.Гансүх: Яг зөв. Ажлын алба, МУУҮА, НФФ, Засгийн газрын байгууллага гээд энэ 4 байгууллагын вэбсайт дээр ирцийн бүртгэлийг мэдээлж байя.

С.Мэндсайхан: Хоёр санал байна. Журман дээр хуралдааныг Ерөнхий сайд даргална, эзгүйд нь Уул уурхайн сайд орлоно гэсэн байна. Амьдрал дээр энэ хэрэгжихгүй л болов уу. Тиймээс хурлыг орлогч дарга Уул уурхайн сайд даргалаад, эзгүйд нь ҮЗ-ийн нарийн бичгийн дарга даргална гэвэл яасан юм. Хоёрдугаарт, Уул уурхайн сайд гэхгүйгээр Уул уурхайн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн гэсэн ерөнхий нэр томъёогоор нэрлэх гэсэн саналтай байна. ТАН эвсэл гэж байна, энэ ямар эсвэл юм бэ? Урд талд нь товчилсон үгийн тайлбар гэж оруулах нь зүйтэй.

Л.Гансүх: За эхний саналын тухайд Ерөнхий сайд удирдана гэдгээрээ л явж байг л дээ. Үүнийг санал хураая. Өөрчилъе гэсэн нь гараа өргөөрэй. 4 хүн байна. За тэгэхээр энэ хуучнаараа үлдлээ. Харин товчилсон үгийн тайлбар оруулах саналыг авъя. За тэгээд журмын төслөө батлая. Цаашид өөрчлөх шаардлагатай зүйл гарвал ҮЗ дараагийн хурлаараа хэлэлцээд явъя.

Х.Лхамаа: Ажлын хэсгийн хурал дээр яриад тохирчихсон асуудлыг буцаад Үндэсний зөвлөлийн хурал дээр задалж ярьмааргүй байна.

Л.Гансүх: Ажлын хэсгийн гишүүн биш олон гишүүд Үндэсний зөвлөлд орж ажиллаж байгаа. Үндэсний зөвлөл асуудлыг задлаж ярина уу, буцаана уу, цоо шинэ асуудал гаргаж ирнэ үү бүх эрх нь байгаа. Тиймээс тэр дэмий байх. За тэгээд сүүлийн 6 дугаар асуудалдаа оръё.

ШИЙДВЭРЛЭСЭН нь: 1. Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилгыг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, хянан зохицуулах үүрэг бүхий Үндэсний

зөвлөлийн ажиллах журмыг Үндэсний зөвлөлийн гишүүдээс гаргасан саналуудыг тусган шинэчлэн батлав.

2. Үндэсний зөвлөлийн ажиллах журам шинэчлэн батлагдсантай холбогдуулан Үндэсний зөвлөлийн 2006 оны 5 дугаар сарын 12-ны өдрийн хуралдаанаар баталсан "Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилгыг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, хянан зохицуулах үүрэг бүхий Үндэсний зөвлөлийн ажиллах журам"-ыг хүчингүй болсонд тооцов.

VI. ХЭЛЭЛЦСЭН нь: Монгол Улсын ОҮИТБС-ын долдугаар буюу 2012 оны нэгтгэлийн тайлан гаргах аудитын консерциумыг сонгон шалгаруулах удирдамжийг батлах тухай

Ш.Цолмон: За энэ нилээн хэвшил болсон асуудал байгаа. 2012 оны нэгтгэлд дунджаар 200 гаруй компанийг оруулая гэсэн саналтай байна. Хоёрдугаарт, 40 сая төгрөгний босгыг хэвээр үлдээе. Гуравдугаарт, аудитыг олон улсын ISRS-4400 гэсэн стандартаар хийнэ гэдэг заалтыг нэмж оруулсан. Яагаад үүнийг тодруулж өгсөн бэ гэхээр 2011 оны нэгтгэл тайлангийн тендерийг шалгаруулах явцад маргаан гарсан л даа. Монгол Улсын хуулиар нэг байгууллагын аудитыг аудитын нэг компани 3-аас дээш жил хийж болохгүй гэж заасан байдаг юм байна лээ. Тэгээд тендерт оролцогч зарим компаниудаас энэ бол аудитын ажил гэж маргаан үүсгээд сонгон шалгаруулалтын ажил бараг 3 сар удааширсан. Тийм учраас бид энэ талаар Олон улсын нарийн бичгийн дарга нарын газраас тодруулаад дээрх стандартаар явна гэдгийг зааж өгсөн. Ер нь сонгон шалгаруулалтыг 12 сарын дундуур зарлаад 1 дүгээр сарын дундуур сонирхлоо илэрхийлсэн материалыг хүлээж авч, үнэлэх ийм төлөвлөгөөтэй байна. Үнэлгээний хороог байгуулсан. Харин энэ үнэлгээний хороонд томилогдсон гишүүд Сангийн яамнаас тусгай үнэмлэх авах ёстой юм байна лээ. Энэ ажил бас хугацаа авах байх. /Танилцуулгыг хавсаргав./

Л.Гансүх: Бид сая бүх компанийг тайлан гаргуулна гээд байдаг. Энэ дээр 200 компанид л аудит хийнэ гэсэн байна. Эхнээсээ л асуудалд орох нь. Тэгээд одоо яах вэ?

Ш.Цолмон: 1800 компанид бүгдэнд нь аудит хийнэ гэдэг бодит байдал дээр бүтэн жил ажиллаад ч боломжгүй байх. Ийм учраас Олон улсаас юу гэж зөвлөж байна гэхээр тодорхой хэмжээний босго байна, аудитын ажил нь үр дүнтэй байх ёстой, зардал мөнгөө хэмнэсэн байх ёстой гэсэн шаардлагуудыг тавьдаг. Тэргүүлэгч компаниудад нэгтгэл хийх нь үр дүнтэй гэж байгаа. Нөгөө талаас зардал мөнгөний асуудал байна. Нэгтгэлийн ажлын зардлыг улсын төсвөөс гаргаж байгаа. Бид 2013 онд 200 сая төгрөгийг улсын төсвөөс авахаар төлөвлөгөө өгч, батлуулаад байна. Энэ мөнгө 1800 компанид аудит хийхэд хүрэлцэхгүй байх. За дээр нь аудитын нэгтгэлийг олон улсын болон дотоодын хамтарсан аудитын консорциум 60 хоногт хийж гүйцэтгэх ёстой. 1800 компанийн тайланг гаргадгаараа гаргаад, үүнийг нийтэд ил тод мэдээлээд, харин үүнээс материаллаг төлбөрийн хэмжээгээр нь сонгон авч 200 гаруйг нь аудитад оруулах саналтай байна.

Н.Дорждарь: Бид 1800 компанид аудит хийе гэж яриагүй. Тэр 40 сая төгрөгийн босго бол болж байна. Харин Засгийн газар 518 компаниар гаргасан энэ анхны мэдээллийг олон нийтэд мэдээлдэг байя гэж байгаа юм. Ер нь бол Олон улсын дүрэмдээ бүх компаниуд тайлан гаргадаг байна гэж заасан байдаг. Бид удахгүй баталгаажуулалтад орно. Гэтэл бүх компанийн тайланг гаргаж чадаагүй байх юм бол баталгаажуулалтад унах байх. Харин 200 компанид аудит хийх асуудал бол өөр хэрэг юм. Энэ бол санаачилгын нэг л ажил юм.

Л.Гансүх: Босго 40 сая төгрөг гэдэг нь болж байна. Гэхдээ 1800 компани дотроос 40 сая төгрөгөөс дээш татвар, төлбөр төлсөн нь яг хэд байх нь тодорхойгүй байна. 300 ч юмуу 400 ч юмуу бид мэдэхгүй. Хоёрдугаарт, сая Дорждарь хэллээ. Олон улсад бүх компанийг хамруулах ёстой гэж байна. Энэ нь яг тоогоороо явдаг юм уу? Жишээлбэл, манай нэгтгэлийн тайланд хамарсан 200 компанийн төлсөн татвар, төлбөр нь нийт уул уурхайгаас олсон орлогын дийлэнх хувийг эзлээд, аудитад ороогүй үлдэх 1600 компани нийт орлогын 1 хувь ч юмуу бага хувийг эзэлж байвал яах вэ? Хэрэв төлж буй дүнгээр нь авч үзвэл бид ажлаа хийгээд явж байна гэсэн үг.

Н.Дорждарь: За таны хэлснээр 200 компанийн дүн нь нийт орлогын 99 хувь гэдгийг яаж мэдэх вэ? Цаана нь үлдэж буй 1600 компанийн дүн бага юм гэдгийг нотлох нь тэр Засгийн газрын анхны тайлангаар гараад ирэх байх.

Ш.Цолмон: Дунджаар 200 компани гэсэн байгаа л даа. Бид тендерт оролцож буй компаниудад бас нэг баримжаа өгөхгүй бол тэдэнд зардал мөнгөө тооцоход ч хүндрэлтэй байна байх. Хэн хэндээ ойлгомжтой байх үүднээс тодорхой байх хэрэгтэй.

С.Энхтуяа: Монгол Улсад идэвхтэй үйл ажиллагаа явуулж байгаа уул уурхайн 200-300 компани байдаг гэж үздэгийн. Тэгэхээр дунджаар 200 гэдэг нь ойролцоо тоо байх гэж бодож байна.

Л.Гансүх: Дунджаар 200 гэдгээр нь явъя. Энэ тоо өөрчлөгдвөл тухайн үед нь ажлын хэсгийн хурлаараа хэлэлцээд явъя. Харин энэ босго 40 сая нь юунаас гарсан тоо вэ?

Ш.Цолмон: Энэ бол аж ахуйн нэгжийн орлогын албан татвар, нөөц ашигласны төлбөрийн нийлбэр.

Л.Гансүх: 40 сая гэдэг татварт ер нь ямар босго вэ? Компанийн хэдэн хувь нь ийм хэмжээний татвар төлөх үү?

Б.Баттөмөр: 40 сая гэдэг нь уул уурхайн компанийн хувьд бага дүн юм, бусад салбарын хувьд өндөртөө орно.

Л.Гансүх: За тэгвэл 40 саяын босго тавъя. Эхний тайланг АМГ, ТЕГ гаргаад, Сангийн яам 40 саяын босго гэдгээр шигшээд тоогоо гаргаж ирнэ биз дээ. За тэгээд энэ удирдамжаа батлая даа. За ингээд өнөөдрийн хурал өндөрлөлөө. Дараагийн хурал ойрхон зарлаж магадгүй. Бэлтгэлтэй байгаарай. За баярлалаа.

ШИЙДВЭРЛЭСЭН нь: 1. Монгол Улсын ОҮИТБС-ын долдугаар буюу 2012 оны нэгтгэлийн тайлан гаргах аудитын консерциумыг сонгон шалгаруулах удирдамжийг Үндэсний зөвлөлийн гишүүдээс гаргасан саналыг тусган зөвшөөрөв.

Үндэсний зөвлөлийн хурал 19 цаг 35 минутад өндөрлөв.

Хуралдааны тэмдэглэлтэй танилцсан:

Ерөнхий сайдын ахлах зөвлөх,
Үндэсний зөвлөлийн нарийн бичгийн дарга Л.Гансүх

Хурлын тэмдэглэл хөтөлсөн:

Ажлын албаны санхүүгийн мэргэжилтэн Б.Дэлгэрмаа